

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ 1 ДҮГЭЭР
УЛИРЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2010 оны 3 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2010 оны 3 дугаар сарын байдлаар нэгдсэн төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 120.5 хувийн биелэлттэй, нийт зарлага 83.0 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн нийт алдагдал 58.0 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 177.3 тэрбум төгрөгөөр бага байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2010 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр 554.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 95.1 тэрбум төгрөгөөр буюу 20.7 хувиар давж биелж, 2009 оны мөн үеийнхээс 66.2 хувиар буюу 220.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мон үеийн	жилийн Төлөв.	2010 ОНЫ 3-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв. 3	Гүйцэт. 4	(4 : 3) 5	(4 : 2) 6	(4 - 3) 7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	333.9	2,427.0	459.7	554.8	120.7	22.9	95.1
УРСГАЛ ОРЛОГО	333.5	2,403.4	459.0	539.7	117.6	22.5	80.7
ТАТВАРЫН ОРЛОГО	277.2	2,083.7	408.5	480.3	117.6	23.0	71.7
Орлогын албан татвар	74.5	698.6	149.7	187.4	125.2	26.8	37.8
ААН-ийн орлогын албан татвар	40.7	268.8	53.0	80.5	151.8	29.9	27.5
Хувь үний орлогын албан татвар	28.3	119.2	30.0	31.8	106.0	26.7	1.8
Зарим үтгэгдэхүүний үнийн өсөлтийн татвар	5.6	310.6	66.7	75.2	112.7	24.2	8.5
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	60.2	278.6	59.9	64.6	107.9	23.2	4.7
Өмчийн татвар	2.3	10.5	2.2	2.6	117.5	24.8	0.4
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	92.4	696.0	131.5	146.8	111.7	21.1	15.3
Гадаад худалдааны орлого	23.5	153.1	27.9	31.5	113.1	20.6	3.7
Бусад татвар	24.3	246.8	37.5	47.3	126.3	19.2	9.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56.2	319.7	50.4	59.4	117.8	18.6	9.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.5	1.6	0.7	0.6	85.0	39.4	-0.1
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.0	22.0	0.0	14.5	0.0	66.1	14.5

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 86.6 хувь нь татварын орлогоос, 10.7 хувь нь татварын бус орлогоос, 2.6 хувь нь тусламжийн орлогоос, 0.1 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Орлогын албан татвар 37.8 тэрбум, дотоодын бараа, үйлчилгээний татвар 15.3 тэрбум, бусад татварын орлого 9.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн, АНУ-аас эдийн засгийн хямралтай байгаа орнуудад үзүүлж буй 14.5 тэрбум төгрөгийн мөнгөн тусламж олгосон нь нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		ХХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	367.1	442.2	59.1	65.5	11.8	18.9	118.0	121.4
УРСГАЛ ОРЛОГО	335.0	397.7	52.0	58.5	11.8	18.9	76.9	80.3
ТАТВАРЫН ОРЛОГО	288.3	341.7	48.6	55.1	11.8	18.9	76.9	80.3
Орлогын албан татвар	119.7	155.6	30.0	31.8	0.0	0.0	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	53.0	80.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	30.0	31.8	0.0	0.0	0.0	0.0
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	66.7	75.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	76.9	80.3
Өмчийн татвар	0.0	0.0	2.2	2.6	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	130.2	146.4	1.3	0.5	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	27.9	31.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	10.6	8.1	15.1	20.3	11.8	18.9	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46.7	56.0	3.4	3.4	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.7	0.6	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	32.1	44.5	6.4	6.4	0.0	0.0	41.1	41.1

- Улсын төсвийн орлого 442.2 тэрбум өгрөгт хүрч 20.5 хувиар буюу 75.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын орлого 51.8 хувиар буюу 27.5 тэрбум, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын орлого 12.7 хувиар буюу 8.5 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 19.7 хувиар буюу 16.6 тэрбум, гадаад худалдааны орлого 13.1 хувиар буюу 3.7 тэрбум, татварын бус орлого 19.8 хувиар буюу 9.2 тэрбум, тусламжийн орлого 38.8 хувиар буюу 12.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелж, бусад татварын орлого 22.9 хувиар буюу 2.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 65.5 тэрбум өгрөгт хүрч, 10.8 хувиар буюу 6.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Өмнөговь, Сэлэнгэ, Орхон аймгуудын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого харгалзан 929.6 сая, 1171.1 сая, 1580.2 сая төгрөгөөр, Нийслэлийн хувь хүний орлогын албан татварын орлого 2504.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн нь орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлжээ.
- Хүний хөгжлийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 18.9 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 60.7 хувиар буюу 7.1 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 121.4 тэрбум болж 2.9 хувиар буюу 3.4 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасалдсан байна. Улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох 41.1 тэрбум төгрөгийн татаасыг бүрэн олгосон байна.

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2010 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр 846.1 тэрбум өгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 602.4 тэрбум өгрөг байхаар төлөвлөгдсөн өнөө гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 664.0 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зардал 78.5 хувийн, улсын төсвийн зарлага 500.2 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардал 83.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Халамжийн сангаас халамжийн тэтгэвэрт 13.0 тэрбум, жирэмсэн, амаржсан

эхчүүдэд 4.8 тэрбум, алдарт эхийн одонтой эхүүдэд 8.5 тэрбум, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтөнд 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Орон нутгийн төсвийн зарлага 54.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 84.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүний хөгжлийн сангаас иргэдэд олгох бэлэн мөнгөнд зориулж 87.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зард ал 112.4 хувийн буюу 92.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ТӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2010 ОНЫ 3-Р САР		ХУВЬ		ЗӨРҮҮ (4 - 3)
			Төлөв.	Гүйцэтг.	(4 : 3)	(4 : 2)	
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	440.9	2,785.6	846.1	664.0	78.5	23.8	-182.0
УРСГАЛ ЗАРДАЛ	406.2	2,168.6	673.8	512.6	76.1	23.6	-161.2
Бараа, үйлчилгээний зардал	221.7	1,050.9	291.4	242.8	83.3	23.1	-48.7
Цалин хөлс	137.6	599.0	149.9	141.8	94.6	23.7	-8.1
Нийгмийн даатгалын шимтгэл	12.5	57.3	14.3	13.0	90.7	22.7	-1.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	84.1	451.9	141.6	101.0	71.4	22.4	-40.5
Зээлийн үйлчилгээний төлбөр	5.2	42.8	8.1	7.8	96.7	18.3	-0.3
Татаас ба шилжүүлэг	179.3	1,074.8	374.2	262.0	70.0	24.4	-112.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27.7	518.4	135.0	41.4	30.6	8.0	-93.6
Дотоод эх үүсвэрээр:	23.6	480.2	132.2	40.7	30.8	8.5	-91.5
Гадаад эх үүсвэрээр	4.1	38.2	2.8	0.6	22.4	1.6	-2.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	6.9	98.6	37.3	110.1	295.2	111.7	72.8
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-72.8	234.8	-214.8	27.1	(12.6)	11.5	241.9
НИЙТ ТЭНЦЭЛ	-106.9	-358.6	-386.3	-109.2	28.3	30.5	277.1

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2010 оны эхний 3 сард олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 44.8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 11.5 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан байна. Иргэдэд олгох бэлэн мөнгөний дэвтэр хэвлүүлэхэд зориулж 875.4 сая өгрөг, гадаад паспорт хэвлүүлэхэд зориулж 240.0 сая төгрөгийн зээлийг улсын төсвөөс олгосон байна. Зоос банкин дахь мөнгөн хөрөнгийн баталгаа болгож Засгийн газрын 100,0 тэрбум төгрөгийн бондыг Монголбанкинд арилжааллаа. Мөн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах “4000 орон сууц” хөжлөхийг хэрэгжүүлэхээр 6,0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг арилжиж, бондын үхсвэр ийг Орон сууцны санхүүжилтийн корпорацид дамжуулан зээлдүүллээ.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 27.1 тэрбум төгрөг ийн ашигтай, нийт тэнцэл 109.2 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 46.4 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 58.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.